



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ТАЙЛАН 2018

**МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГ ТООЦОХ
АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

**АУДИТЫН НЭР: ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД
ХЭРЭГЖИЖ БУЙ МАЛЖУУЛАХ ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨРИЙН 2014-2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

АУДИТЫН КОД: ХЭА-2018-01-ГА

Агуулга		
Аудитыг гүйцэтгэсэн: Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар Аудитын менежер Д.Оюунтуяа Ахлах аудитор Н.Туяа Аудитор Ц.Энхтүвшин 2018 он 10 сарын 10 Холбоо барих: Утас 7056-2112 Цахим хаяг khentii@audit.gov,mn Байршил Хэнтий аймаг Хэрлэн сум Чингис хот Аймгийн ЗДТГ-ын байр 320 тоот	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
	АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА	3
	АУДИТЫН ДҮН	4
	БҮЛЭГ 1: Малчин өрхөд мал худалдан авч өгөх ажлын зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай	5
	1.1 Малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт малчин өрхийн 62.9% нь хөтөлбөрийн шаардлага хангаагүй байна.	5
	1.2 “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд мал худалдах, худалдан авах арга хэмжээг нээлттэй, ил тод зохион байгуулаагүй байна.	5
	1.3 Малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт өрхийн 30.0% нь санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн байна.	6
	БҮЛЭГ 2: Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийн 54.8% нь мал маллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдсан байна.	8
	2.1 Малжуулах арга хэмжээнд хамрагдсан бага малтай малчныг дадлагажуулах мал маллагааны ур чадвар олгох ажил зохион байгуулагдаагүй байна.	8
	2.2 Сургалтын нийт зардлын 63.2%-ийг хоол цай, буудлын зардалд зарцуулжээ.	10
	БҮЛЭГ 3: “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллаагүй байна.	11
	3.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт хийгдсэн боловч судалгаа, дүн шижилгээ хангалтгүй байна.	11
	3.2 Малжуулах арга хэмжээний 2014, 2015 оны гэрээний хугацаа дууссан боловч дүгнэж, үр дүнг тооцоогүй байна.	12
	АУДИТЫН ДҮГНЭЛТ	14
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	14
	АУДИТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	15
	Тайлангийн төсөлд ирүүлсэн санал ба тайлбар	15
Тайланг баталгаажуулсан шийдвэр	16	
ХАВСРАЛТ	17	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР		
АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын Стандарт	
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	
АДЗ	Амьжиргаа дэмжих зөвлөл	
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	
ТББ	Төрийн бус байгууллага	
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл	
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар	

АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 05 өдрийн А/06 тушаалыг үндэслэн Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

2. Аудитын зорилт:

Хэнтий аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Малжуулах төсөл” хөтөлбөрийн 2014-2017 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт ба зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтанд хүргүүлж, аудитын дүнг аймгийн ИТХ-д танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудитыг хийлээ. Үүнд:

- ❖ Малчин өрхийг малжуулах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан эсэх
- ❖ Төсөлд хамрагдсан өрхийг сургалтад хамруулж, хөтөлбөрийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
- ❖ Малжуулах төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцож, хяналт тавьж ажилласан эсэх

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн ХЭДС-аас санхүүжсэн “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2014-2017 онд хэрэгжүүлсэн малжуулах арга хэмжээ, мал маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэх ур чадварын сургалт болон бусад санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн баримт, бүртгэл тайлагнал, статистик мэдээ, холбогдох бусад баримт материалыг хамруулав.

4. Аудитад ашигласан арга зүй, стандарт:

Аудитыг гүйцэтгэхэд аудитын удирдамж АДБОУС 3000, 3100-ийг ашиглан “Төрийн хяналт шалгалтын стандарт”, “Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг баримтлан төслийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтийн талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга, лавлагаа, тодруулга авсны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, асуудал бүрээр судалгаа гарган дүн шинжилгээ хийж, санхүүгийн баримтыг тулган баталгаажуулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

5. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- “Төсвийн тухай” хууль
- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай” хууль
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014 оны 05 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр, төслүүд батлах тухай”

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 07 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр батлах тухай”
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 09 дүгээр тогтоол “Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн батлах тухай”
- Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/12 дугаар тушаал “Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн батлах тухай”
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай”
- Бусад холбогдох тогтоол шийдвэр, заавар журам

6. Ерөнхий мэдээлэл

ХЭДС-аас санхүүжсэн “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн зорилго нь малчдад мал маллах арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх ур чадвар олгох, малжуулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 2014-2017 онд 914.4 сая төгрөгийг зарцуулж, богд шилжүүлснээр 15710 толгой малаар 210 малчин өрхийг малжуулж, малын үнийн 624.7 сая төгрөгийг буцаан төлөхөөр гэрээ байгуулан олгосон байна.

2014-2015 онд 16 сум, 2 тосгоны 98 малчин өрхийн 196 малчин малжуулах арга хэмжээнд хамрагджээ. Арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд бог малд шилжүүлснээр нийт 6128 мал олгосон ба малын төрлөөрөө адуу 5, үхэр 224, хонь 3061, ямаа 1875 байна. 2017 оны мал тооллогын дүнгээр бог малд шилжүүлснээр нийт 29230 малтай болсон бөгөөд малын төрлөөр адуу 1058, үхэр 1121, хонь 7416, ямаа 8535 болж өсжээ.

2016-2017 онд 14 сум, 1 тосгоны 112 малчин өрхийн 224 малчин малжуулах арга хэмжээнд хамрагджээ. Арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд бог малд шилжүүлснээр нийт 9583 мал олгосон ба малын төрлөөрөө адуу 13, үхэр 123, хонь 5537, ямаа 3574 байна. 2017 оны мал тооллогын дүнгээр бог малд шилжүүлснээр нийт 34229 малтай болсон бөгөөд малын төрлөөр адуу 1216, үхэр 995, хонь 10550, ямаа 10219 болж өсжээ.

Малжуулах арга арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд аж ахуй эрхлэлтийн болон малын эрүүл мэнд, мал маллах арга ажиллагаа, малын ашиг шимийг боловсруулах сургалт, туршлага солилцох уулзалт 3 удаа зохион байгуулагдаж нийт 115 малчин хамрагдан 29.2 сая төгрөг зарцуулагдсан байна.

Мөн малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд нийт 1.5 сая төгрөгийн 3333 боодол өвс, 600 шуудай хивэг худалдан авчээ.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Дадал, Жаргалтхаан, Батноров, Норовлин, Өмнөдэлгэр сумын 6 малчин өрхөд нийт 30.0 сая төгрөгийн үнэтэй бага оврын тракторыг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон байна. Үүнээс гадна 18 ажил олгогч малчинд нийт 18.0 сая төгрөгийн урамшуулал олгожээ.

АУДИТЫН ДҮН**БҮЛЭГ 1: МАЛЧИН ӨРХӨД МАЛ ХУДАЛДАН АВЧ ӨГӨХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ.****1.1 МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДСАН НИЙТ МАЛЧИН ӨРХИЙН 62.9% НЬ ХӨТӨЛБӨРИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙНА.**

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 2014 онд 35, 2015 онд 63, 2016 онд 48, 2017 онд 64, нийт 210 малчин өрх хамрагджээ.

Арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн насны хязгаарыг 2014 онд 40 хүртэл, 2015, 2016 онд 35 хүртэл, 2017 онд 15-39 настай байхаар тогтоосноос энэ хязгаарт хамаарахгүй нийт 11 (2014 онд 6, 2015 онд 1, 2016 онд 2, 2017 онд 2 малчин) малчин байна.

Арга хэмжээнд хамрагдах малчин өрх бог малд шилжүүлснээр 2014 онд 50-100, 2015 онд 100, 2016 онд 150, 2017 онд 200 толгой малтай байх шаардлагыг малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт өрхийн 9.5% буюу 20 өрх хангаагүй байна. Энэ нь 2014 онд 2 өрх, 2015 онд 14 өрх, 2016 онд 4 өрх байгаа нь малын тоог богд шилжүүлснээр тооцоогүйтэй холбоотой.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт өрхийн 15.3% буюу 28 малчин өрх (2014 онд 25 өрх, 2015 онд 3 өрх) хамрагдах хүсэлтээ бичгээр гаргаагүй байна.

Малжуулах арга хэмжээнд 2015-2017 онд хамрагдсан нийт 175 өрхийн хөдөлмөрийн чадвартай малчин гишүүн, малын тоог аймгийн Статистикийн хэлтсийн мэдээллийн сантай тулган баталгаажуулахад 62.9% нь буюу 110 өрх шаардлага хангаагүй байна. Тулган баталгаажуулах явцад хөдөлмөрийн чадвартай 2 гишүүнтэй байх шаардлагыг 76 өрх, малын тоонд тавих хязгаарыг 44 өрх хангаагүй ба 44 өрх малын “А” дансгүй байгаа нь шаардлага хангахгүй өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулсныг нотлож байна. (Хавсралт 1)

Энэ нь багийн Засаг дарга нар ам бүл болон малын тоог буруу тодорхойлсон, мөн сумын АДЗ ажил үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн нь харагдаж байна.

Цаашид “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд гэр бүл болсон залуу малчин өрхийг хамруулахад чиглүүлэх нь зүйтэй.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд хашаа хороо барих, хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг дэмжлэг туслалцаа үзүүлэхэд мал аж ахуй эрхлэх материаллаг баазтай эсэх тухай мэдээлэл нь ихээхэн чухал юм. Мал аж ахуй эрхлэх материаллаг баазын талаарх мэдээллийг 2015 оноос эхлэн хяналтын хуудсаар авдаг болсон боловч 179 малчин өрхийн мэдээлэл хангалтгүй, мэдээллийн үнэн зөвийг нягталж, баталгаажуулдаггүй байна.

Иймд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдаж байгаа малчин өрхийн талаарх мэдээллийг сумын ЗДТГ-ын төсөв, төрийн сангийн мэргэжилтнээр баталгаажуулан, аймгийн Статистикийн хэлтсийн мэдээллийн сантай тулгаж байх шаардлагатай

1.2 "МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХҮРЭЭНД МАЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ АРГА ХЭМЖЭЭГ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт өрхийн 38.6% буюу 81 (2014 онд 28, 2015 онд 38, 2016 онд 1, 2017 онд 14) малчин өрхийг дэмжсэн сумын АДЗ-ийн санал байхгүй байна. (Хавсралт 2)

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийг сонгон шалгаруулах ажлыг 2014 онд Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн, 2015, 2016, 2017 онуудад ажлын хэсэг зохион байгуулжээ.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт өрхийн 64.3% буюу 135 (2014 онд 35, 2015 онд 36, 2016 онд 0, 2017 онд 64) малчин өрхийн судалгааг хийсэн баримт байгүйгээс үзэхэд аймгийн ХХҮХ (хуучнаар Хөдөлмөрийн хэлтэс) сонгон шалгаруулах ажлыг шаардлагын түвшинд зохион байгуулаагүй байна. (Хавсралт 2)

2014 онд малчин өрхийг хэрхэн сонгосон талаарх баримт, материал байхгүй ба 2015 онд аймгийн АДЗ-ийн дэмжсэн 27 өрх, ажлын хэсгийн сонгон шалгаруулсан 36 өрх, нийт 63 өрхийг Хөдөлмөрийн хэлтсийн даргын тушаалаар малжуулах арга хэмжээнд хамруулах шийдвэр гаргажээ. Харин малчин өрхийг малжуулах арга хэмжээг 2016 онд харьцангуй чанартай зохион байгуулсан байна.

Малжуулах арга хэмжээнд хамруулах малчин өрхийг 2017 онд хэрхэн сонгон шалгаруулсныг нотлох баримт байхгүй боловч, ХХҮГ-ын даргын тушаалаар аймгийн АДЗ-ийн дэмжсэн 64 малчин өрхийг хамруулах шийдвэр гаргажээ.

Аудитад "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн малжуулах арга хэмжээг зохион байгуулах талаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээлсэн, мал худалдан авах үйл ажиллагааг аймгийн ХХҮГ-аас хуулийн дагуу ил тод зохион байгуулсан баримт материал ирүүлээгүй тул дүгнэлт өгөх боломжгүй байна.

Иймд аймгийн ХХҮГ "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн зорилгыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан сурталчлан танилцуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

"Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдаж мал нийлүүлж буй малчин иргэдийг сонгон шалгаруулсан ямар нэгэн баримт байхгүй, тэднийг хэрхэн сонгон шалгаруулсан нь тодорхойгүй байна.

Иймээс мал худалдан авах ажиллагааг сум тус бүрээр багцлан, 20.0 сая төгрөг хүртэлх худалдан авалтыг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулах боломж байгааг судлаж үзэх нь зүйтэй.

Арга хэмжээний хүрээнд мал худалдан авахад зориулж 2014 онд 34 малчинтай 140.0 сая төгрөг, 2015 онд 61 малчинтай 267.4 сая төгрөг, 2016 онд 47 малчинтай 207.0 сая төгрөг, 2017 онд 58 малчинтай 300.0 сая төгрөгийн нийт 210 малчинтай 914.4 сая төгрөгийн худалдах, худалдан авах гэрээ байгуулжээ. (Хавсралт 3)

Мал худалдсан иргэнтэй байгуулсан 2014 оны мал нийлүүлэх гэрээнд малын үнэ, 2015, 2017 оны худалдах, худалдан авах гэрээнд малын тоо, үнэ тусгагдаагүй байна. Мал худалдах, худалдан авах 2014, 2015, 2016 оны гэрээнүүдийн худалдан авагч талыг төлөөлж Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн, 2017 онд сумын халамжийн мэргэжилтэн нар гарын


үсэг зурсан боловч хөрөнгө зарцуулах эрх бүхий албан тушаалтан баталгаажуулаагүй байна.

1.3. МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДСАН НИЙТ ӨРХИЙН 30.0% НЬ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУГАЦААГ ХЭТРҮҮЛСЭН БАЙНА.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт 210 малчин өрхөд бог малд шилжүүлснээр 914.4 сая төгрөгийн 15710 толгой мал худалдан авч өгч, олгосон санхүүгийн дэмжлэгийн үнийн дүнгийн 50-100% буюу нийт 624.7 сая төгрөгийг малчин эргүүлэн төлөхөөр “Малчин өрхтэй байгуулах гэрээ”-г байгуулсан байна. (Хавсралт 3)

Санхүүгийн дэмжлэг олгоход тавигдах малын тооны шалгуурт хамаарагдахгүй 20 малчин өрхөд 80.2 сая төгрөгийн 1361 толгой мал олгосон байна. Үүнд 2014 оны 2 өрхөд 10.0 сая төгрөг, 2015 оны 14 өрхөд 54.2 сая төгрөг, 2016 оны 4 өрхөд 49.0 сая төгрөг олгожээ.

Мал худалдан авахад олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 2018 оны эхний хагас жилийн байдлаар төлбөл зохих 399.7 сая төгрөгнөөс 328.6 сая төгрөг төлөгдөж эргэн төлөлт 82.2% (2014 онд 65.7%, 2015 онд 92.1%, 2016 онд 84.1%, 2017 онд 81.2%)-тай байна. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн байдлыг сум тус бүрээр харуулбал



Малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт малчин өрхийн 30.0% буюу 63 өрхөд олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 28.3%-тай байна. Үүнээс 3 өрх аудитын хугацаанд 1.1 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулжээ.

Эргэн төлөлт огт хийгдээгүй нийт 34 малчин өрхийн дотор малжуулах гэрээний хугацаа дууссан Дадал, Баянхутаг, Батноров, Батширээт, Баянмөнх, Галшар, Хэрлэн, Мөрөн, Дэлгэрхаан сумын 12 өрх байна.

Аймгийн ХХҮГ (хуучнаар Хөдөлмөрийн хэлтэс) 2016 онд 1 өрх, 2017 онд 9 өрх, 2018 онд 27 өрх, нийт 37 өрхөд хугацаа хэтэрсэн эргэн төлөлтийг барагдуулах тухай мэдэгдэл хүргүүлжээ. Эргэн төлөлтийн хугацаа хэтрүүлж, мэдэгдэл авсан 5 өрх бүрэн төлж барагдуулсан ч Батширээт, Баянхутаг, Галшар, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Хэрлэн сум болон Бэрх, Хурх тосгоны малчдын эргэн төлөлт хангалтгүй байна.

Эргэн төлөлт хангалтгүй байгаа 7 өрх 2017 оны эцсээр мал тоолуулаагүй, 2 өрхийн арга хэмжээнд хамрагдах үеийн малын тоо буурсан байна. Бусад 54 малчин өрхийн малын тоо 103.0-920.3%-иар өссөн боловч эргэн төлөлт хангалтгүй байгаа нь “Малчин өрхийг малжуулах арга хэмжээний гэрээ”-ний хавсралт эргэн төлөлт хийх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүргээ ХХҮГ (хуучнаар Хөдөлмөрийн хэлтэс) хангалтгүй хэрэгжүүлж ирсэнтэй холбоотой.

Иймд эргэн төлөлтийн хувьтай уялдуулан дараа онд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тогтоож сумын Засаг даргатай байгуулах гэрээнд тусгах нь зүйтэй.

Аудитын явцад эргэн төлөлт удаашралтай байгаа Батноров сумын 2 өрх, Биндэр сумын 1 өрх, Батширээт сумын 3 өрх, Мөрөн сумын 6 өрх, Баянхутаг сумын 3 өрх, Хэрлэн сумы 5 өрх, нийт 20 малчин өрхөөс 2014-2016 онд гэрээ хийсэн 14 өрхийг сонгон түүвэрлэн уулзалт, ярилцлага хийж, алслагдсан өрхүүдтэй утсаар холбогдож, мал хүлээн авч арга хэмжээнд хамрагдсан эсэхийг баталгаажуулан, эргэн төлөлтийн төлөлтийн талаарх тодрууллаа. Түүвэрт хамрагдсан малчин өрхүүд малжуулах арга хэмжээнд хамрагдаж, гэрээнд заасан малыг хүлээн авсан ба гэрээний үүрэг, хариуцлагыг буруу ойлгосон, бэлэн мөнгөний дутмаг байдлаас шалтгаалан эргэн төлөлт удааширсан байна.

Аудитын явцад аймгийн ХХҮГ эргэн төлөлтийг эрчимжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, нийт 28.2 сая төгрөгийг төвлөрүүлж чадсан байна. (Хавсралт 3)

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан ч өөр аймаг суманд амьдарч байгаа малчин өрхийн гэрээг харьяаллын дагуу тухайн аймаг, сумын хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж, бүртгүүлдээ байх заалтыг “Малчдын хөдөлмөрийг дэмжих хөтөлбөр”-т тусгаж өгөх нь зүйтэй байна.

БҮЛЭГ 2: МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДСАН МАЛЧИН ӨРХИЙН 54.8% НЬ МАЛ МАЛЛАГАА, АЖ АХУЙ ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТАНД ХАМРАГДСАН БАЙНА.

2.1 МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДСАН БАГА МАЛТАЙ МАЛЧНЫГ ДАДЛАГАЖУУЛАХ, МАЛ МАЛЛАГААНЫ УР ЧАДВАР ОЛГОХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДААГҮЙ БАЙНА.

Хөтөлбөрт хамрагдаж буй малчин өрхөд аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалт явуулах, туршлага солилцох уулзалт зохион байгуулах, малын хашаа хороо барих, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг дэмжлэг туслалцаа үзүүлэхэд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малчин өрхийг малжуулах арга хэмжээнд зарцуулах зардлын 20%-ийг, 2015, 2016, 2017 онд 5%-ийг хуваарилан зарцуулахаар хөтөлбөрт тусгажээ.

А. Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчдын аж ахуй эрхлэлт, мал маллагааны арга ажиллагааг сайжруулах арга хэмжээ

2014 онд “Бизнесээ эхэл” сургалтыг нийт 40 цагийн 5 өдрийн хөтөлбөрөөр №20/1615 дугаартай мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа явуулах гэрчилгээтэй “Хэрлэн бизнес, хөгжил нийгэмлэг” ТББ-ийн дэргэдэх сургалтын төв зохион байгуулжээ. Сургалтад малжуулах арга хэмжээнд хамрагдсан 34 өрхийн 35 малчин хамрагдсан ба 2 өдрийн ирцийн бүртгэлтэй ч суралцагчдад гэрчилгээ олгосон баримтгүй байна.

2014 онд “Сүү, цагаан идээ боловсруулах” сургалтыг онолын 42 цаг, дадлагын 102 цагийн 14 өдрийн хөтөлбөрөөр 9071016133 улсын бүртгэлтэй “Итгэл бүтээмж” төвийн дэргэдэх №20/1514 дугаартай мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа явуулах гэрчилгээтэй “Интек” сургалтын төв зохион байгуулжээ. Сургалтад 25 иргэн хамрагдсаны 19 нь малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрх байна. Сургалт зохион байгуулах гэрээ байгуулж, ирцийн бүртгэл хийж, суралцагч бүрд чадамжийн гэрчилгээ олгожээ.

2017 онд Залуу малчин өрхийг мал маллах арга ажиллагааны болон аж ахуй эрхлэх ур чадварын 12.5 цагийн сургалтыг зохион байгуулж 63 малчин хамрагджээ. Сургалтын 7 цагт 8 төрийн байгууллага, 3 ТББ малчны үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл өгч, 5.5 цагт аж ахуй эрхлэлтийн сургалтыг “Хэрлэн бизнес, хөгжил нийгэмлэг” ТББ зохион байгуулжээ. Сургалтын нийт цагийн 56.0%-д төрийн байгууллагууд мэдээлэл хийсэн нь хөтөлбөрийн зорилттой уялдаагүй байна.

Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээний сэдэв, агуулгыг малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийн гишүүдийн санал, бодлыг үндэслэн боловсруулах, сургалтыг цөөн хоногоор, оновчтой арга зүй ашиглан зохион байгуулах нь зүйтэй.

Б. Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийн материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2014 оны хөтөлбөрийн нэг онцлог зорилт нь материаллаг баазыг бэхжүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн ашгийн бус ажлыг нийтийг хамарсан ажлын хүрээнд зохион байгуулахаар хөтөлбөрт тусгасан байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийн хадлан, тэжээлийг бэлтгэх зорилгоор 2014 онд 3333 боодол өвс, 600 шуудай хивгийг аж ахуйн нэгжээс нийт 17.5 сая төгрөгөөр худалдан авсан нь хөтөлбөрт заасан “ашгийн бус ажлыг нийтийг хамарсан ажлын хүрээнд зохион байгуулах” шаардлагатай гэсэн заалттай зөрчилдөж байна.

Хөтөлбөрт хамрагдсан 38 малчин өрхөд 600 шуудай хивэг, 725 боодол өвсийг олгожээ. Харин 2330 боодол өвсийг дараа онд 6 суманд хуваарилан хүргүүлсэн, 278 боодол өвсийг сумдад өвс хүргэсэн тээврийн зардалд олгосон нь гэж тайлбарласан боловч нотлох баримт байхгүй байна.

Цаашид малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийн материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглэгдсэн хашаа, хороо барих, хадлан тэжээл, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зэрэг дэмжлэг тусалцаа үзүүлэхдээ энэ хөтөлбөрт хамрагдсан малчдын хүчээр зохион байгуулах нь зүйтэй.

В. Малчин ажил олгогчийг дэмжих арга хэмжээ.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2014 оны хөтөлбөрт богд шилжүүлснээр 1000-аас дээш тооны малтай, туслах малчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, туслах малчинд 12 сарын хугацаатай 200-аас дээш толгой мал маллуулж, сар тутам хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгож, сайн дурын НДШ-ийг нь төлсөн малчин ажил олгогчид 1.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 1 удаа олгохоор заажээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд 2014 онд 8, 2015 онд 10 малчин ажил олгогчид нийт 18.0 сая төгрөгийн урамшуулал олгожээ. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т өөрчлөлт орсон тул 2015 онд олгосон 10 сая төгрөгийн урамшууллыг “Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар

олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр"-ийн санхүүжилтээс олгожээ. Малчин ажил олгогчид тавих шаардлагыг хангаж байгаа боловч туслах малчинд олгосон цалин хөлс, мал маллагааны арга туршлагаа зааж сургах шавь, дагалдан сургалтын гэрээ, цалин хөлс олгосон талаар нотлох баримт хангалтгүй байхад урамшууллыг шилжүүлэн олгожээ.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2015, 2016, 2017 оны малжуулах арга хэмжээнд хамрагдсан цөөн малтай малчин өрх дадлагажуулагч малчинтай байх, дадлагажигч малчин өрхийн гишүүдэд мал маллах арга ухааныг шавь сургалтаар олгоход зориулж 2015 онд 8 хүнд 1.1 сая төгрөг, 2016 онд 5 хүнд 0.7 сая төгрөг хуваарилагдсан боловч зарцуулагдаагүй байна. Гэтэл 2015 онд 1, 2016 онд 9 малчин өрх дадлагажуулагч малчинтай байх шаардлагатай байжээ.

Г. Малчдын бүлэгт багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2015 оны хөтөлбөрт 400 хүртэл толгой малтай 4-өөс доошгүй малчин өрх бүхий малчдын бүлэгт хадлан тэжээл бэлтгэх, малын хашаа хороо засах, сүү цагаан идээ боловсруулах зэрэг мал аж ахуйн болон фермерийн багаж, тоног төхөөрөмж худалдан авч өгөх үйл ажиллагааны хүрээнд 6 малчны бүлэгт малчин өрхийг малжуулах арга хэмжээний зардлын 10.1% буюу 30.0 сая төгрөгөөр анжистай 6 трактор худалдан авч өгсөн байна.

Малчдын бүлэг 4-5 өрхтэй ба Дадал сумын “Сэрүүн булаг”, Өмнөдэлгэр сумын “Булган” малчдын бүлгүүдээс бусад бүлэг бог малд шилжүүлснээр 400-аас илүү малтай байгаа нь хөтөлбөрт заасан шаардлагыг хангахгүй байна.

Багаж, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, баримт материалд хангалтгүй байх тул дүгнэлт өгөх боломжгүй байна.

2.2 СУРГАЛТЫН НИЙТ ЗАРДЛЫН 63.2 ХУВИЙГ ХООЛ ЦАЙ, БУУДЛЫН ЗАРДАЛД ЗАРЦУУЛЖЭЭ.

Малчдын аж ахуй эрхлэлт, мал маллагааны арга ажиллагааг сайжруулах арга хэмжээний хүрээнд 2014 онд малчин өрхийн тэргүүн нарт зориулсан “Бизнесээ эхэл” сургалтад 35 малчин хамрагдаж, 14.0 сая төгрөг, гэрийн эзэгтэй нарт зориулсан “Сүү цагаан идээ боловсруулах” сургалтад 19 малчин хамрагдаж 7.0 сая төгрөг, 2017 онд “Мал маллагааны арга ажиллагаа болон аж ахуй эрхлэх ур чадвар олгох” сургалтад 61 малчин хамрагдаж, 8.3 сая төгрөг, нийт 115 малчин хамрагдаж, 29.2 сая төгрөг зарцуулсан байна.

“Бизнесээ эхэл” сургалтын нийт зардлын 26.3% буюу 3.7 сая төгрөгийг сургалтын багшийн хөлсөнд шилжүүлсэн ба хоол, цайнд 4.7 сая төгрөг, буудалд 3.8 сая төгрөг, замын зардалд 0,6 сая төгрөг, товхимол, дурсгалын зураг зэрэг бусад зардалд 1.2 сая төгрөг зарцуулжээ.

Сургалтад зарцуулагдсан 3.8 сая төгрөгийн хоол, 3.8 сая төгрөгийн буудлын зардлын зарцуулалтын баримт (жагсаалт), 3 өдрийн суралцагчдын ирцийн бүртгэл байхгүй байна.

“Сүү цагаан идээ боловсруулах” сургалтад нийт 7.0 сая төгрөг зарцуулсны 3.5 сая төгрөгийг хоолонд, 3.5 сая төгрөгийг сургалтын багшийн зардалд зарцуулжээ. Сургалтын багшийн зардал 3.5 сая төгрөгийг “Хөдөлмөрт бэлтгэх” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлсэн байна.

Сургалтад нийт 25 хүн хамрагдсаны дотор малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамрагдаагүй 5 малчин байгаа бөгөөд эдгээр хүмүүсийн сургалтын зардалд 2.1 сая төгрөг ногдож байна.

2017 онд зохион байгуулсан залуу малчдын мал маллах арга ажиллагаа болон аж ахуй эрхлэх ур чадвар олгох сургалтад нийт 8.3 сая төгрөг зарцуулсны 3.1% буюу 0.3 сая төгрөгийг сургалтын багшийн хөлсөнд шилжүүлсэн ба буудалд 1.3 сая төгрөг, хоол, цайны зардалд 5.2 сая төгрөг, унааны зардалд 0.6 сая төгрөг, бусад зардалд 0.9 сая төгрөг зарцуулжээ.

Сургалтын зардлын 15.9%-ийг буудал, 64.8%-ийг хоол, цай, 8.0%-ийг замын зардалд, 11.0%-ийг бусад зардал зарцуулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан байна.

Цаашид сургалтын хоол цай, буудлын зардалыг сургалтын хоногийг цөөрүүлэх замаар бууруулж, ур чадвар, арга ажиллагааг эзэмшихэд зориулагдах зардлыг нэмээдүүлэх, сургалт зохион байгуулах ажлын гэрээний хэрэгжилт, сургалтын чанарт дүн шинжилгээ хийж санхүүжилтийг шилжүүлж байх нь зүйтэй.

Малчдын бүлэгт багаж, тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээнд зориулан 2015 онд 30.0 сая төгрөгийг малчны бүлэгт шилжүүлэн анжистай бага оврын трактор худалдан авах ажлыг зохион байгуулжээ. Энэхүү арга хэмжээнд хамрагдсан малчин өрхүүд бүгд малжуулах арга хэмжээнд хамрагдаагүй бөгөөд 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1.8 сая төгрөгийн эргэн төлөлтийн үлдэгдэлтэй байна.

Дадал сумын “Сэрүүн булаг” малчдын бүлгийн 0.6 сая төгрөг Тариалан дэмжих санд тушаасныг залруулах шаардлагатай.

Норовлин сумын “Дэвжих” малчны бүлэгт 2017 онд шаардлага хүргүүлсэн боловч одоо болтол 1.2 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Өвлийн бэлтгэл хангах арга хэмжээнд зориулан 2014 онд 10.0 сая төгрөгийн 3333 боодол өвс, 7.5 сая төгрөгийн 600 шуудай хивгийг худалдан авч бэлтгэсэн байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан 33 малчин өрхөд 7.5 сая төгрөгийн хивэг, 7 өрхөд 2.2 сая төгрөгийн өвсийг хуваарилан олгожээ. Харин 7.0 сая төгрөгийн өвсийг сумын ЗДТГ-аар дамжуулан малчин өрхөд хүргэсэн, 0.8 сая төгрөгийн өвсийг өвс тээвэрлэсэн жолоочийн хөлсөнд олгосон гэх боловч баримтаар нотлогдохгүй байна.

Олгосон өвсийг сум бүрээр жагсаавал:

№	Сумын нэр	Малчин өрх	Боодол өвсний тоо	Өвсний нийт үнэ /мян.төг/
1	Баянмөнх	5	500	1500.0
2	Өлзийт	2	200	600.0
3	Батноров	5	500	1500.0
4	Бэрх	2	400	1200.0
5	Хэрлэн	1	230	690.0
6	Баянхутаг	5	500	1500.0
	Тээврийн зардал		278	834,0
	ДҮН	20	2608	7827.0

БҮЛЭГ 3: “МАЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ТООЦОЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**3.1 ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХЯНАЛТ ХИЙГДСЭН БОЛОВЧ СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл болон ХХҮГ, (хуучнаар Хөдөлмөрийн хэлтэс) байнгын хяналт тавин, тайлан мэдээг сар, улирлаар гаргаж Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвд дараа сарын 3-ны дотор хүргүүлэхээр заажээ.

Аймгийн ХХҮГ, (хуучнаар Хөдөлмөрийн хэлтэс) хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналтыг 2014 онд хийгээгүй, 2015 онд 6, 2016 онд 1, 2017 онд 7 удаа хийжээ.

2015 онд хийсэн явцын хяналтаар давхардсан тоогоор 38 суманд ажиллаж, 243 малчин өрхийн мал маллах материаллаг бааз, суурьтай танилцсан байна. Явцын хяналтаар мал олголт, хөтөлбөрт хамрагдсан малчдын нөхцөл байдлыг судлах ажил голлон хийгдсэн ч үр дүн, цаашид авах арга хэмжээ, удирдлагад өгөх зөвлөмжийн талаар дурдаагүй, үнэлгээ хийгдээгүй, ажлын тайлангаар хязгаарлагдсан байна.

2017 онд хийсэн явцын хяналтаар давхардсан тоогоор 50 суманд ажиллаж 156 малчин өрхийн мал маллах материаллаг бааз, суурьтай танилцахын зэрэгцээ санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, төлөгдөөгүй үлдэгдлийн шалтгааныг тодруулах судалгаа хийж, нийт 227.3 сая төгрөгийн эргэн төлөлтөд шаардлага хүргүүлсэн байна. Үүний үр дүнд 2014 оны төлөгдөөгүй үлдэгдлээс 14.2 сая төгрөг, 2015 оны төлөгдөөгүй үлдэгдлээс 37.4 сая төгрөгийг төвлөрүүлж, үр дүнтэй ажилласан байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээний явцад хөтөлбөрт хамрагдаж байгаа малчин, малчин өрхийн судалгаа, мэдээллийг цуглуулах, малчин өрхтэй гэрээ байгуулах зэрэг ажлуудыг сайжруулах талаар зарим нэг арга хэмжээг авсан байна. Тухайлбал 2015 оноос малжуулах арга хэмжээнд хамрагдаж байгаа өрх бүрд хяналтын хуудас нээсэн, малчин өрхтэй байгуулах гэрээнд эргэн төлөлтийн хуваарь, барьцаа хөрөнгийн гэрээ хавсаргасан бол 2016 оноос мал худалдаж авсан тооцооны хуудастай болж 2017 оноос малын тоог сумын Санхүүгийн алба албажуулах болжээ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, сумын ИТХ, ЗДТГ, захиргаа, иргэдийн төлөөллийн байгууллагаас хяналт тавьсан баримт, нотолгоо байхгүй байна. Аймгийн ХХҮГ, (хуучнаар Хөдөлмөрийн хэлтэс) хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд тогтмол бэлтгэн холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлдэг байна.

Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналтын дүнг нэгтгэн, гарсан зөрчил, дутагдлын учир шалтгааныг тогтоох, цаашид авах арга хэмжээг тодорхойлж байх шаардлагатай.

3.2 МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2014, 2015 ОНЫ ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА ДУУССАН БОЛОВЧ ДҮГНЭЖ, ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ БАЙНА.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2014, 2015 онд малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхтэй байгуулсан гэрээг 2017 онд, 2016 оны гэрээг 2018 онд, 2017 оны гэрээг 2019 онд үр дүнг тооцох юм

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан 14 өрх огт малгүй болж, 8 өрхийн мал 340 толгойгоор буурсан ч нийт өрхийн 89.5% буюу 188 өрхийн мал анх байснаас 44029 толгойгоор өссөн эерэг үр дүн гарсан боловч 2017 онд хугацаа нь дууссан малчин өрхтэй байгуулсан 2014, 2015 оны гэрээний хэрэгжилт, үр дүнг тооцох ажил зохион байгуулагдаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- ❖ Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн 24.8 хувь нь хөтөлбөрийн шаардлагыг хангаагүй, нийт өрхийн 30.0 хувь нь санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг гэрээний дагуу хугацаанд нь барагдуулаагүй, мал худалдах, худалдан авах ажиллагааг нээлттэй ил тод зохион байгуулж чадаагүй байгааг нь арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.
- ❖ Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийг тоног, төхөөрөмжийн дэмжлэгт хамруулаагүй, бага малтай малчныг дадлагажуулах, шавь сургалтад хамруулаагүй, сургалтын зардлын ихэнх хэсгийг хоол, буудлын зардалд зарцуулсан нь хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
- ❖ Аймгийн ХХҮГ (хуучнаар Хөдөлмөрийн хэлтэс) малжуулах арга хэмжээний гэрээг дүгнээгүй, судалгаа, дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийн үр дүнг тооцон Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлд танилцуулж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ




АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА С.ЭРДЭНЭЖАРГАЛД

1. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдаж байгаа малчин өрх, малчин сонгон шалгаруулах ажлыг нээлттэй, ил тод, үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн төлөвлөгөө гарган, хариуцсан албан тушаалтны үр дүнгийн гэрээний биелэлттэй уялдуулан ажиллах.
2. Малжуулах арга арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд аж ахуй эрхлэлтийн болон малын эрүүл мэнд, мал маллах арга ажиллагаа, малын ашиг шимийг боловсруулах сургалт, туршлага солилцох уулзалт болон бусад дэмжлэг туслалцаанд зориулсан хөрөнгийг батлагдсан хуваарийн дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах
3. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн үр дүнг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж, хүрсэн үр дүнг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнүүлж, цаашид авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлж батлуулж байх шаардлагатай.

Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 3-р сарын 15-ны дотор албан бичгээр Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

2. АУДИТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ БА ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал	Тайлбар
<div style="text-align: center;">  <p>АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p> <p>ХЭНТИЙ АЙМАГ ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР</p> <p>23123 Чингис хот, Хэрлэн сум 1-р баг Тэмүүжингийн гудамж-01, Утас, Факс: 70-56-38-13 E-mail: www.khentii.hudulmur-halamj.gov.mn</p> <p>2018. 10. 30 № 855</p> <p>танай _____-ны № _____-т</p> <p>Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай</p> <p>Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн гүйцэтгэл, 2014-2017 онд хамрагдсан малчин өрхүүдийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.</p> <p>1.1 Нийт өрхийн 15.3% буюу 32 малчин өрх (2014 онд 25 өрх, 2015 онд 3 өрх, 2017 онд 4 өрх) гэсний 2017 онд 4 өрх нь хамрагдах хүсэлтэй бичгээр өгсөн тул хасуулах.</p> <p>1.2 “Эргэн төлөлт огт хийгдээгүй нийт 54 малчин өрхийн дотор малжуулах гэрээний хугацаа дууссан Дадал, Баянхутаг, Батноров, Батширээт, Баянмөнх, Галшар, Хэрлэн, Мөрөн, Дэлгэрхаан сумын 12 өрх байна.” гэснийг 2018 оны эхний хагас жилийн байдлаар эргэн төлөлт хийгдээгүй нийт 34 малчин өрхийн дотор малжуулах гэрээний хугацаа дууссан Дадал, Баянхутаг, Батноров, Батширээт, Баянмөнх, Галшар, Хэрлэн, Мөрөн, Дэлгэрхаан сумын 12 өрх байна гэж өөрчлөх. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд мал худалдах, худалдан авах арга хэмжээг нээлттэй, ил тод зохион байгуулах, хөрөнгө зарцуулах эрх бүхий албан тушаалтнаар батлуулах, худалдан авах гэрээнд малын тоо, үнийг тусгах зэрэг ажлуудыг 2018 оны гэрээнд тусган ажиллаж байна.</p> <p>2.1 “Сургалтад малжуулах арга хэмжээнд хамрагдсан 34 өрхийн 35 малчин хамрагдсан ба 2 өдрийн ирцийн бүртгэлтэй ч сургалтад чадамжийн гэрчилгээ олгосон баримт байхгүй” гэсний Сургалтад малжуулах арга хэмжээнд хамрагдсан 34 өрхийн 35 малчин хамрагдсан ба 2 өдрийн ирцийн бүртгэлтэй ч сургалтад чадамжийн гэрчилгээ олгосон баримт байхгүй гэдгийг хасах.</p> <p>3.2 “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан 14 өрх огт малгүй болж, 10 өрхийн мал 340 толгойгоор буурсан ч нийт өрхийн 88.6% буюу 186 өрхийн мал анх байснаас 42817 толгойгоор өссөн үр дүн гарсан байна.” гэснийг “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан 14 өрх огт малгүй болж, 8 өрхийн мал 340 толгойгоор буурсан ч нийт өрхийн 88.6% буюу 188 өрхийн мал анх байснаас бог малд шилжүүлснээр 44029 толгойгоор өссөн үр дүн гарсан байна. “ гэж өөрчлөх саналтай байна.</p> <div style="text-align: center;"> <p>ДАРГА  С.ЭРДЭНЭЖАРГАЛ</p>  <p>000076</p> </div> </div>	<p><i>Хүлээн авч, тайланд засвар оруулав.</i></p> <p><i>Хүлээн авч, тайланд засвар оруулав.</i></p> <p><i>Чадамжийн гэдэг үгийг хасав.</i></p> <p><i>Тайлангийн төсөл боловсруулагдах явцад ирүүлсэн 2 өрхийн мэдээлэл тусгагдаагүй байгааг залруулав.</i></p>

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ШИЙДВЭР**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2018 оны 11 дугаар сарын 30

Дугаар А/34

Чингис хот

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 12.40 дэх заалт, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдах Зөвлөлийн 2018 оны 09 тоот хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Хэнтий аймгийн хэмжээнд хэрэгжиж буй малжуулах төсөл хөтөлбөрийн 2014-2017 оны үйл ажиллагаа”-нд хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг Даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫН НЭГТГЭЛ

№	Зөрчлийн агуулга	Алдаа зөрчлийн		Үүнээс:			
		тоо	Дүн /сая.төг/	ЗӨ	ТА	АШ	ХХБ
1	Шаардлага хангаагүй малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулсан	59	0.0			1	
6	Мал худалдан авах ажиллагааг ил тод зохион байгуулаагүй	57	234.0	1			
3	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хугацаандаа барагдаагүй	63	84.4			1	
4	Малжуулах арга хэмжээг дэмжсэн арга хэмжээнүүд шаардлагын дагуу зохион байгуулагдаагүй	2	0.0			1	
5	Анхан шатны баримтын бүртгэлгүй ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан	3	21.0			1	
7	Малжуулах арга хэмжээг дэмжсэн арга хэмжээний зардлыг арвилан хэмнэлт, үр дүнгүй зарцуулсан	3	20.6	1			
8	"Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн үр дүнг тооцоогүй	98	221,2	1			
	ДҮН		581.2	3		4	